



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 08

Сүхбаатар сум

2024 оны 3 дугаар улиралд хийсэн
дотоод аудитын дүнгийн тухай


Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан Өргөн Сэлэнгэ, Гавшгай-Ус, Тохилог хараа, орон нутгийн өмчийн ААТҮГ-ын, Алтанбулаг, Зүүнбүрэн, Сант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлийн дүн, дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, үр ашиг, үр нөлөө, ил тод байдлыг ханган ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсүгэй. дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Орон нутгийн өмчит ААТҮГ-ын захирал, төсвийн төвлөрүүлэн захирагч нарт даалгасугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга:



Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)


Гишүүд:

Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод
аудитын албаны дарга)


4324009008



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
дарга)



Б.Янжинлхам
(Хууль зүйн хэлтсийн дарга)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)



А.Гэрэлмаа
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22-ны
өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт

ДОТООД АУДИТААР ӨГСӨН ДҮГНЭЛТИЙН ЖАГСААЛТ

(мян.төг)

д/д	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчлийн дүн	Аудитын дүгнэлт
1	Өргөн Сэлэнгэ ААТҮГ	889,974.0	"Хангалтгүй"
2	Гавшгай-Ус ААТҮГ	1,914,935.1	"Хангалтгүй"
3	Тохилог хараа ААТҮГ	857,788.4	"Сайжруулах шаардлагатай"
4	Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч	497,943.4	"Сайжруулах шаардлагатай"
5	Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч	120,944.3	"Сайжруулах шаардлагатай"
6	Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч	3,931.3	"Сайжруулах шаардлагатай"
	Нийт зөрчлийн дүн	4,285,516.5	